

Golomt Capital[®]

ДЭЛХИЙН

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ**

2025.06.23

Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- АНУ-ын зүгээс Ираны цөмийн байгууламжид агаарын цохилт өгсний дараа Ойрх Дорнодод хурцадмал байдал дээд цэгтээ хүрлээ. Иран хариу арга хэмжээ болгон дэлхийн газрын тосны тээвэрлэлтийн гол судас болсон Хормузын хоолойг хааж болзошгүйг анхааруулсны дараа АНУ Хятад улсад хандан дипломат алхам хийхийг ятгав.
- Холбооны Нөөцийн Сан бодлогын хүүг өөрчлөлгүй хэвээр үлдээж, тодорхойгүй байдал өндөр түвшинд хэвээр байгааг онцлов.
- Геополитикийн хурцадмал байдал, АНУ-ын эдийн засгийн үзүүлэлтүүдийн сул байдал, ХНС-гийн хүлээлт зэргээс шалтгаалан хөрөнгийн зах зээл хэлбэлзэлтэй, тодорхойгүй нөхцөлд оршсоор байна.
- 5-р сард жижиглэн худалдаа өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.4%-иар өссөн нь 2023 оны 12-р сараас хойших хамгийн өндөр үзүүлэлт болжээ.



S&P 500 индексийн 2025 оны таамаглал

Deutsche Bank	7,000
Société Générale	6,750
BMO Capital Markets	6,700
Bank of America	6,666
Barclays	6,600
RBC Capital Markets	6,600
Wells Fargo	6,500
Citigroup	6,500
Goldman Sachs	6,500
Morgan Stanley	6,500
JPMorgan Chase	6,500
UBS	6,400
Дундаж	6,678





АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2025.06.16-06.22

ОЙРХИ ДОРНОДЫН ХУРЦАДМАЛ БАЙДЛЫН УЛМААС ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ УНАВ

Зах зээл долоо хоногийн турш Ойрх Дорнод дахь хурцадмал байдалтай холбоотой олон мэдэгдэл, мэдээллүүдийн дунд хэлбэлзсэн юм. Пүрэв гарагт Ерөнхийлөгч Дональд Трамп Ирантай “тун удахгүй хэлэлцээ хийх магадлал өндөр” гэж мэдэгдсэн нь Баасан гарагт хөрөнгийн зах зээлийн хэлбэлзэлийг тогтворжуулсан байна. Холбооны Нөөцийн Сан бодлогын хүүг өөрчлөлгүй хэвээр үлдээж, тодорхойгүй байдал өндөр түвшинд хэвээр байгааг онцлов. Энэ нь бодлогын хүүг дараалан дөрөв дэх удаагаа өөрчлөлгүй хадгалж буй тохиолдол юм. Дарга Жером Пауэлл хэвлэлийн бага хурал дээр “тодорхойгүй байдал өндөр хэвээр байгаа ч эдийн засаг тогтвортой байдалд байна. Бид эдийн засгийн шинэчлэлтүүдэд цаг тухайд нь хариу өгөхөд бэлэн байна” гэж мэдэгдэв. Мөн ХНС-гийн эдийн засгийн төлөвийн тоймд (Summary of Economic Projections) энэ оны үлдсэн хугацаанд хүү хоёр удаа бууруулах төлөв хэвээр байна. Гэсэн хэдий ч 2025 оны төгсгөл гэхэд инфляц, ажилгүйдлийн хүлээлт өссөн бол ДНБ-ийн өсөлтийн төлөв буурчээ. Баасан гарагийн өглөө CNBC-д өгсөн ярилцлагадаа Кристофер Уоллер хамгийн ойрдоо долоодугаар сард хүүг бууруулах боломжтой гэсэн санаа илэрхийлсэн нь тухайн өдөр зах зээлд дэмжлэг үзүүлсэн.

Жижиглэнгийн борлуулалт буурч, орон сууцны шинэ барилга эхэлсэн тоо 5 жилийн доод түвшинд хүрэв. Өнгөрсөн долоо хоногийн турш нийтлэгдсэн макро эдийн засгийн статистикууд ерөнхийдөө хүлээлтээс сул байлаа. Мягмар гарагт АНУ-ын Хүн амын тооллогын газраас гаргасан 5-р сарын жижиглэнгийн борлуулалтын тайланд борлуулалт хоёр дахь сар дараалан буурч, 0.9%-иар унасан нь анхаарал татлаа. Энэ нь хэсэгчлэн автомашины борлуулалтын огцом бууралтаас шалтгаалсан бөгөөд 4-р сард Трампын засаг автомашинд 25%-ийн тариф тогтоосонтой холбоотойгоор 3-р сард автомашины эрэлт огцом өсөөд буцаж буурсан хэмээн тайлбарлаж байна. Гэсэн ч дотоодын ДНБ-д шууд нөлөөлдөг "control group" борлуулалт (автомашин, шатахуун гэх мэт хэлбэлзэлтэй бүлгүүдийг хассан) 5-р сард 0.4%-иар өссөн нь спорт бараа болон тавилгын хэрэглээний өсөлттэй холбоотой байв. Үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн талаарх мэдээллүүд ч сөрөг гарсан. Үндэсний Орон Сууц Барилгачдын Холбоо (НАНВ)-ны 6-р сарын барилгын индекс 32 нэгж болж буурсан нь 2022 оны 12-р сараас хойших хамгийн бага түвшин юм (50-аас доош нь сөрөг хүлээлтийг илэрхийлдэг). НАНВ-ийн дарга Бадди Хьюгес “өндөр хүү, тариф, эдийн засгийн тодорхойгүй байдал нь худалдан авагчдыг хүлээлтийн байдалд оруулж байна” хэмээв. Түүнчлэн, Хүн амын тооллогын газар болон Орон сууц, Хот байгуулалтын яамны хамтарсан тайлангаас үзэхэд шинэ орон сууцны ажил 5-р сард 9.8%-иар буурч, улирлын тохируулгатай жилийн хэмжээгээр 1.26 сая болж буурсан нь 2020 оны 5-р сараас хойших хамгийн доод түвшин юм.

Дүгнэлт: Геополитикийн хурцадмал байдал, АНУ-ын эдийн засгийн үзүүлэлтүүдийн сул байдал, ХНС-гийн хүлээлт зэргээс шалтгаалан хөрөнгийн зах зээл хэлбэлзэлтэй, тодорхойгүй нөхцөлд оршсоор байна. Ойрх Дорнодын хурцадмал байдлын даамжирч байгаа нь зах зээлд сөрөг сигналыг өгч байна.



Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2025.06.16 – 06.22

ХЯТАДЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ УНАЛАА.

Хятадын эх газрын хувьцааны зах зээл уналттай хаагдлаа. Хөрөнгө оруулагчид эдийн засгийн нөхцөл байдалд анхаарлаа төвлөрүүлснээр, дотоодын CSI 300 индекс 0.45%-иар, Шанхайн нэгдсэн индекс 0.51%-иар буурсан байна. Харин Хонконгийн Хан Сэнг индекс 1.52%-иар унажээ.

Хятад улсын эдийн засаг хоёрдугаар улиралд тогтвортой өсөлт үзүүлэх төлөвтэй байгааг гурван гол үзүүлэлт харуулсан байна. Үүнд, 5-р сард жижиглэн худалдаа өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.4%-иар өссөн нь 2023 оны 12-р сараас хойших хамгийн өндөр үзүүлэлт болжээ. Гэвч аж үйлдвэрийн үйлдвэрлэл болон эхний таван сарын үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалт эдийн засагчдын таамагласнаас доогуур гарсан байна. Түүнчлэн, жижиглэн худалдааны энэ өсөлт нь богино хугацааны нөлөөллөөс үүдэлтэй байж магадгүйг шинжээчид онцолж байна. Тухайлбал, засгийн газрын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн гэр ахуйн цахилгаан бараа болон хэрэглээний бусад бүтээгдэхүүнийг шинэчлэх худалдаа солилцооны хөтөлбөр нь хэрэглээг түр хугацаанд нэмэгдүүлсэн байж болзошгүй юм.

Мөн энэ долоо хоногийн эхээр гарсан нэгэн тайланд Хятадын үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн сулрал үргэлжилж байгааг онцолсон. Bloomberg агентлагийн мэдээлснээр, 5-р сард 70 хотод шинэ орон сууцны үнэ өмнөх сараас 0.22%-иар, хуучин орон сууцны үнэ 0.5%-иар буурсан нь сүүлийн долоон болон найман сарын хамгийн том бууралт болжээ. Хятадын эрх баригчдын хувьд орон сууцны зах зээлийн удаан үргэлжилсэн уналтыг зогсоож, дотоодын хэрэглээг урт хугацаанд дэмжих замаар АНУ-ын нэмэгдсэн тарифын сөрөг нөлөөг зөөлрүүлэх нь чухал зорилт болоод байна. Гэвч өнгөрсөн есдүгээр сард үл хөдлөхийн зах зээлийг дэмжих зорилгоор хэрэгжүүлсэн урамшууллын хөтөлбөрийн үр нөлөө буурч байгааг дээрх тоон мэдээлэл харуулж байна.

Golomt_Capital published on TradingView.com, Jun 23, 2025 00:19 UTC-4

Hang Seng Index Futures - 1M - HKEX Q23,180 H24,409 L22,514 C23,483 +297 (+1.28%) -38 (-0.16%)
VWAP (Decade) 21,187 24,907 17,466 28,628 13,745



Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

Most Anticipated Earnings Releases for the week beginning June 16, 2025									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	
 POWERFLEET	 digital turbine	 JABIL	 Beyond Air	 AURORA	 Smith & Wesson			 Kroger	
 ReNew POWER	 LENNAR	 TEN LTD	 LA BOY	 LIVEONE				 accenture	
	 PetMeds	 ANTALPHA	 VistaGen Therapeutics	 GMS				 DARDEN RESTAURANTS	
	 HIGHTIDE	 VINCE.	 VistaGen Therapeutics	 KORN FERRY				 CARMAX	
	 INDUSTRIES	 WILEY							
http://eps.sh/cal								© 2025 Earnings Whispers	

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

Most Anticipated Earnings Releases for the week beginning June 23, 2025									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	
 Commercial Metals	 kb HOME	 CARNIVAL CORPORATION & P&C	 FedEx	 General Mills	 Micron	 Acuity Brands	 Nike	 apogee enterprises inc.	
 FACTSET		 TD SYNEX	 BlackBerry	 PAYCHEX	 Jefferies	 Walgreens Boots Alliance	 CONCENTRIX		
		 WORTHINGTON INDUSTRIES	 BlackBerry	 DAKTRONICS	 Worthington Steel	 LINDSAY INDUSTRIES	 AMERICAN OUTDOOR BRANDS		
		 AeroVironment	 Anterix	 WINNEBAGO	 H.B. Fuller	 McCormick	 ENERPAC TOOL GROUP		
				 NOVAGOLD	 Steelcase	 HIVE			
					 MillerKnoll	 ORION			
http://eps.sh/cal								© 2025 Earnings Whispers	